УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2016 оны 11 сарын 07 өдөр Дугаар А/147 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар хэсгийн 2.88 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар хэсгийн 2.3.8 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Дулаан техникийн шинэчлэл хөтөлбөр" боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. "Дулаан техникийн шинэчлэл хөтөлбөр"-ийн төслийг 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг /Б.Цэрэнбалжид/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\doc 2016\tushaal 2016.docx

1110300621

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 11 дүгээр сарын 07 өдрийн
А/147 тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Б.Цэрэнбалжид	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Тулга	Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын орлогч дарга
	Ж.Батсайхан	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын дарга
	М.Дэлгэрэх	Агаарын бохирдлыг бууруулах газрын дарга
	Н.Уламбаяр	Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга
	Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн дарга
	Т.Эрдэнэтуяа	Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын Барилга, байгууламжийн хяналтын хэлтсийн дарга
	С.Ариунцэцэг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн
	О.Батмөнх	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дулаан хангамж хариуцсан мэргэжилтэн
	Э.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн хууль, эрх зүйн мэргэжилтэн
	П.Цэрэнжаргал	Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дулааны инженер
	Л.Ариунболд	Монгол базальт ХХК-ний захирал
	Г.Ганзориг	Монгол базальт ХХК-ний гүйцэтгэх захирал
	А.Энхгэрэл	Монгол базальт ХХК-ний эдийн засагч
Нарийн бичгийн дарга:	Д.Оюунжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн барилга хот байгуулалт, орон сууц хариуцсан мэргэжилтэн